



НЭД-ын 2002 оны 14-р захирамжаар хүчингүй

95

МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2001 оны 01 дугаар
сарын 09-ны өдөр

Дугаар 82

Улаанбаатар хот

Дүрэм, бүтэц, орон тоог
батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 3 дугаар заалт, Засгийн газрын 2000 оны 185 дугаар тогтоолын 8 дугаар заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх "Хот байгуулалт, газрын харилцааны газар"-ын дүрмийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Хот байгуулалт, газрын харилцааны газрыг орлогч дарга 1, Хот байгуулалтын хэлтэс, Газрын харилцааны хэлтэс, Хот байгуулалт, газрын мэдээллийн төвтэйгээр, орон тооны хязгаарыг 45 хүртэл байхаар тогтоосугай.

Гурав. Батлагдсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилох, цалин нэмэгдлийг зохих журмын дагуу тогтоох, байгууллагын дотоод журмыг шинэчлэн мөрдөх, үйл ажиллагааны стратеги, хэтийн чиглэлийг боловсруулан энэ оны эхний хагас жилд багтаан батлуулах ажлыг зохион байгуулахыг Хот байгуулалт, газрын харилцааны газар /М.Цэлмэг/-т даалгасугай.

Дөрөв. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2000 оны А/143 дугаар захирамжийн 1 дүгээр заалт, А/160 дугаар захирамжийн 1 дүгээр заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД



Нийслэлийн Засаг даргын 2001 оны
20.09.01 захирамжийн хавсралт

**ХОТ БАЙГУУЛАЛТ, ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ
ГАЗРЫН ДҮРЭМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хот байгуулалт, газрын харилцааны газар нь /цаашид "газар" гэх/ нийслэл хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх үе шатны төсөл, хөтөлбөр, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулах, зураг төслийг захиалах, тэдгээрийг хэрэгжүүлэхэд нийслэлийн газар зохион байгуулалт, барилгажилт, инженерийн хангамж, дэд бүтэц, архитектур төлөвлөлтийн үйл ажиллагааг чиглүүлэн нэгтгэн зангидаж мэргэжлийн удирдлагаар хангах, газрыг үр ашигтай ашиглах, хамгаалах, газрын нэгдмэл сангийн ангиллын болон тусгай хамгаалалттай газрын тооллого явуулах, бүртгэл, судалгаа хөтлөх, газар эзэмшиж ашигласны төлбөрийг ногдуулах, хуримтлуулах ажлыг зохион байгуулах, газар болон хот байгуулалтын мэдээллийн санг эрхлэн хөтөлж, мэдээллээр хангах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үүрэг бүхий төрийн захиргааны орон нутгийн байгууллага мөн.

1.2. Газар нь үйл ажиллагаандаа Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай, Төрийн албаны тухай хууль, Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Барилгын тухай хууль, Газрын кадастрын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжууд, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж, мөрийн хөтөлбөр, энэхүү үүргийг удирдлага болгон ажиллана.

1.3. Газар нь нийслэлийн Засаг дарга, орлогч, Тамгын газрын удирдлаганд үйл ажиллагаагаа явуулж, ажлаа тайлагнана.

1.4. Газрын бүтэц, орон тооны хязгаарыг Нийслэлийн Засаг дарга тогтоож, даргыг томилж, чөлөөлнө. Газрын дарга нь хотын ерөнхий архитектор байна.

1.5. Газрын дарга эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргана.

1.6. Газар нь тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж, банкинд харилцах данстай байна.

1.7. Газрын дарга нь батлагдсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилж, чөлөөлнө.

1.8. Газрын ерөнхий даамалыг Байгаль орчны яамны сайдтай зөвшилцсөний үндсэн дээр Нийслэлийн Засаг дарга томилно.

1.9. Газрын орлогч даргыг Нийслэлийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр томилж, чөлөөлнө.

1.10. Газар нь батлагдсан төсвийг баримтлан санхүүжинэ.

1.11. Газар нь "Газрын тухай хууль"-нд заасны дагуу газрыг хамгаалах, нөхөн сэргээх бодлогыг хэрэгжүүлэх үүрэг бүхий сантай байж болно. Сангийн ажиллах журмыг тусгайлан дүрмээр зохицуулна.

1.12. Газрын дарга нь дэргэдээ хот байгуулалт, дэд бүтэц, газрын харилцаатай холбогдсон асуудалд техникийн шийдэл гаргаж, мэргэжлийн комисст санал боловсруулж оруулах үүрэг бүхий Техникийн зөвлөлтэй байна. Техникийн зөвлөлийн бүрэлдэхүүн болон ажиллах журмыг газрын дарга батлана.

1.13. Архитектур, хот төлөвлөлтийн орон зай, зохиомж, эзэлхүүн төлөвлөлтийн нэгдсэн шийдэл гаргах эрх бүхий Хотын архитектурын зөвлөлийг удирдаж ажиллуулна.

1.14. Хот байгуулалт, газар зохион байгуулалтын бодлогыг хэрэгжүүлэхдээ нийслэлд тухайн жилд газар эзэмшүүлэх, ашиглуулах, хамгаалах хөтөлбөрийг баримтлана.

1.15. Газар нь хот байгуулалт, газрын мэдээллийн нэгдсэн сантай байна.

1.16. Нийслэл Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх үе шатны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, төсөл, хөтөлбөр, инженер геологийн болон бусад хайгуул судалгааны материал, барилгын болон инженерийн шугам сүлжээний зураг төсөл, газрын харилцааны эрх зүйн баримт бичгийг хадгалах үүрэг бүхий хотын архивтай байна.

1.17. Дүүргүүдийн албадыг мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллана.

Хоёр. Газрын үүрэг

2.1. Газар нь Монгол улсын Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх.

2.2. Холбогдох хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийн явц, үр дүнг хугацаанд нь тайлагнаж ажиллах.

2.3. Нийслэлийг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө болон нийслэлийн нутаг дэвсгэрийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, зураг төсөл, салбарын хөгжлийн төлөвлөгөө, гадаад дотоодын хөрөнгө оруулалтаар болон буцалтгүй тусламжаар нийслэлд хэрэгжих хөтөлбөр төслүүдэд оролцох, санал өгөх, техникийн нэгдсэн шийдэл гаргах.

2.4. Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг хангуулах ажлыг удирдан зохион байгуулж хэрэгжүүлнэ.

2.5. Барилгажилт, инженерийн бэлтгэл ажил, тэг тэнхлэг тавих, инженерийн хангамжийн бодлогын хэрэгжилтийг нэгтгэн зангидаж, инженерийн шугам сүлжээний горимын тооцоо, балансад хяналт тавьж ажиллах.

2.6. Эрх бүхий байгууллагын шийдвэрлэснээр нийслэлийн засаг захиргааны нутаг дэвсгэрийн хуваарь, Улаанбаатар хот, хот орчмын бүс, тосгоны эдэлбэр газрын хилийн цэсийг баталгаажуулах ажлыг зохион байгуулж шийдвэрлүүлнэ.

2.7. Нийслэлд тухайн жилд газар ашиглах, эзэмших, хамгаалах хөтөлбөрийг боловсруулна.

2.8. Нийслэлд газрын харилцаа, архитектур, хот байгуулалтын нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх үндэслэл болох нийслэлийн бүс нутгийн хөгжлийн төсөл, Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, тэдгээрийн хүрээнд хийгдсэн инженер геологийн судалгаа, бусад зориулалтын зураглал, хилийн цэсийн баталгаат баримт бичгүүд, геодезийн цэг тэмдэгтүүд, газар зохион байгуулалтын зураг төсөл, гадаад дотоодын хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөтөлбөр, төсөл, төлөвлөгөө, усны эх үүсвэр, нөөцийн судалгаа, дүгнэлт, эрүүл ахуй, ариун цэврийн бүс тогтоосон баримт материал, шийдвэр, зам тээвэр, инженерийн шугам сүлжээний хэтийн төлвийн зураг төсөл, газрын харилцааны эрх зүйн баримт бичгийг зохих шаардлагын хэмжээнд бүрдүүлж, нууцын болон архивын материалуудын иж бүрэн судалгаа, бүртгэл хөтөлж ашиглах, тодотгол, шинэчлэл хийх ажлыг зохион байгуулах.

2.9. Нийслэлд газрын кадастрыг удирдах, зохион байгуулах ажлын хүрээнд:

2.9.1. Нийслэлд газрын тооллого, тоо бүртгэл, газрын кадастрын ажлыг удирдан зохион байгуулж хэрэгжүүлэх.

2.9.2. Газрын нэгдмэл сангийн ангиллын болон тусгай хэрэгцээний газрын тооллогыг явуулах, өөрчлөлт, газрын хөдөлгөөний тайланг нэгтгэн гаргах үйл ажиллагааг мэргэжлийн нэгдсэн удирдлагаар хангаж явуулах.

2.9.3. Газрыг үр ашигтай ашиглах, хамгаалах үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, хадлан бэлчээр, тариалангийн талбай, бэлчээр ашиглалтын горим, хуваарь тогтоож, хяналт тавих.

2.9.4. Газрын төлөв байдал, хянан баталгааг хийлгэх, нийтийн эзэмшлийн газрын ашиглалтыг хариуцагчийг тодорхой болгож, гэрээ байгуулах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах.

2.9.5. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эдэлбэр газрыг бүртгэлд хамруулан, лавлагааны нэгдсэн зургийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээр хөтлөх.

2.9.6. Газрын нэгдмэл сангийн үндсэн, дэлгэрэнгүй ангилалд орж байгаа өөрчлөлт, хөдөлгөөний тайланг Засгийн газарт жил бүр гаргаж өгөх.

2.9.7. Газрын улсын бүртгэлд дараах зүйлүүдийг тусгана: Газар ашиглагч, эзэмшигчээр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн харьяалал, газрын зориулалт, нэгж талбайн хэмжээ, эрх олгосон үндэслэл, уг эрх дуусах хугацаа, тавьсан нөхцөл болзол, хязгаарлалт, эрхийг бусдад шилжүүлсэн тухай тэмдэглэл, нөхөн олговортойгоор эгүүлэн авсан тухай эрх бүхий байгууллагын шийдвэр зэрэг болно.

2.9.8. Газрын чанарын болон эдийн засгийн үнэлгээг хийх, газар болон хот байгуулалтын мэдээллийн санг бүрдүүлэн ажиллах, түүний хэрэгжилтийг зохион байгуулан ажиллана.

2.10. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн шийдвэрийг үндэслэн газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээг байгуулан, гэрчилгээ олгож, гэрээг улирал бүр дүгнэж, холбогдох газруудад тайланг хүргүүлэх.

2.11. Хууль тогтоомжоор тогтоогдсон журам, хувь хэмжээг баримтлан газар ашигласны төлбөрийг тогтоон гэрээнд заасан хугацаанд хотын төсөвт төвлөрүүлэн, төсвийн төлөвлөгөөг биелүүлэх ажлыг зохион байгуулна.

2.12. Нийслэлийн нутаг дэвсгэрт хот суурин газрын батлагдсан ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, мэдээллийн санд тогтмол баяжилт хийлгэж байх.

2.13. Нийслэл хотын барилгажилтыг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу орон нутгийн онцлог, үндэсний архитектурын уламжлал, орон зайн харилцаа, зохиомжинд нийцүүлэн тухайлсан эзэлхүүн төлөвлөлтөөр хэрэгжүүлэх, тохижилт, зам талбай, чимэглэл, урлагийн бүтээлүүд, архитектурын жижиг хэлбэрүүдийн цогцолбороор гүйцэтгэх ажлыг зохион байгуулах.

2.14. Архитектурын дэвшилтэт төлөвлөлт, техник, технологийг нэвтрүүлэх, орон зай ашиглалтыг сайжруулах зорилгоор төрийн бус мэргэжлийн байгууллагуудтай хамтран уран бүтээлчид, барилгачидтай хамтын ажиллагааг өргөжүүлэх.

2.15. Хот байгуулалтын бодлогыг зах зээлийн эдийн засгийн нийтлэг хандлагад нийцүүлэн газрын харилцааг боловсронгуй болгох, түүний тулд эхний ээлжинд хот суурин, эдэлбэр газарт, хот байгуулалтын эдийн засгийн үнэлгээ боловсруулж хэрэгжүүлэх, эдийн засгийн чөлөөт бүс, амралт жуулчлалын болон үндэсний парк зэрэг төслүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг Монгол улсын хүн амын нутагшил, хөгжлийн ерөнхий төсөлтэй уялдуулах бодлого баримтлах.

2.16. Эрхэлж буй ажлын хүрээнд холбогдох зайлшгүй шаардлагатай асуудлаар санал боловсруулан Нийслэлийн Засаг даргад оруулж, шийдвэрлүүлэх.

2.17. Архитектур, хот байгуулалтын үйл ажиллагааны төлөвлөлтийн баримт бичгүүдийг дүүрэг, хороо, оршин суугчдад танилцуулах, сурталчлах, харилцан зөвшилцөж, тэдний оролцоотойгоор хэрэгжүүлэх бодлого баримтлах.

2.18. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хугацаанд нь барагдуулах арга хэмжээ авч, хөнгөн шуурхай болгон сар, улирал бүр тайлагнаж, нийтэд мэдээлж, ил тод болгох.

2.19. Газрын даргын нийтлэг хэм хэмжээ тогтоосон тушаалыг тухай бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтэст ирүүлж хянуулах.

2.20. Байгууллагын хэмжээнд сахилга, дэг журам, төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ажилтнуудын ажлын цаг ашиглалт, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, төсвийн хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллах.

Гурав. Газрын эрх

3.1. Газрын тухай, Хот байгуулалтын болон барилгын тухай хууль, нийслэл, дүүргийн Засаг даргын шийдвэрийг зөрчсөн этгээдэд, түүний гэр буруу зөрчлийн шинж байдал, учруулсан хохирлын хэмжээг харгалзан Монгол улсын Газрын тухай хуулийн 59 дүгээр зүйл, мөн Захиргааны хариуцлагын тухай хуулийн холбогдох заалтын дагуу арга хэмжээ авах.

3.2. Газарт тохирол учруулсан гэм буруутай этгээдээс эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээсэн эсэхээс үл хамааран уг хохирлыг нөхөн төлүүлж, түүнийг арилгахтай холбогдсон зардлыг гаргуулах.

3.3. Газрыг зөвшөөрөлгүйгээр буюу хуурамч аргаар эзэмшсэн, хот төлөвлөлтийн норм дүрэм, ерөнхий төлөвлөгөө зөрчсөн аливаа төрлийн барилга байгууламж дур мэдэн барьсан, газрыг тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн мөн зориулалтын бусаар эзэмшсэн бол холбогдох хууль тогтоомжийн дагуу уг газрыг ашиглах, эзэмших эрхийг хүчингүй болгох, шийдвэрлэх.

3.4. Газар нь хотын инженерийн хангамжийн нэгдсэн бодлогын хэрэгжилтийг техникийн удирдлагаар хангаж, хот байгуулалтын техникийн нөхцөл олгох, хяналт тавих, барилга байгууламжийн байршил тогтоох ба барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл олгох, барилга ашиглалтанд оруулах үйл ажиллагаанд оролцох.

3.5. Барилга байгууламжийн зураг төсөл, барилга угсралт, ашиглалтын үеийн аюулгүй ажиллагаа, барилгын норм дүрмийн хэрэгжилтийг хангуулах үйл ажиллагааг удирдан явуулах.

3.6. Нийслэлийн нутаг дэвсгэр дээр газрын харилцааны маргааныг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх.

3.7. Барилга байгууламжийн чанар байдалд дүгнэлт гаргуулах үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлэх.

3.8. Нийслэлийн нутаг дэвсгэр дээрх өмчийн бүх төрөлд хамаарах бүх үйлдвэр, байгууллага, аж ахуйн нэгж болон иргэдийн ашиглалтын ба эзэмшилтийн газар, тэдгээрийн барьж байгаа барилгуудад саадгүй нэвтрэн орж, Газрын тухай хууль тогтоомж, хотын ерөнхий төлөвлөгөөний биелэлтэнд хяналт тавих, холбогдох бичиг баримт шаардах.

3.9. Газар эзэмшигч, ашиглагчдад газар зохион байгуулалт, газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийлгэх талаар шаардлага тавих, хэрэгжилтэнд хяналт тавих.

3.10. Хот байгуулалтын төслүүдийг үндэслэн нийслэлийн бүс нутгийн хөгжлийн төслийг хэрэгжүүлэх үе шатны төсөл, хөтөлбөрийг санаачлан боловсруулах, дэмжих бодлого баримтлан холбогдох шийдвэрүүдийг гаргуулах.

3.11. Архитектур, хот байгуулалтын үнэт өвийг судлан илрүүлэх, бүртгэл хяналтад авах, хамгаалах, сэргээн засварлах, үндэсний архитектурын уламжлалыг хөгжүүлэх талаар холбогдох байгууллагуудад санал оруулах, шийдвэр гаргуулах.

3.12. Хот байгуулалтын төслүүдийг хэрэгжүүлэхийн тулд эхний ээлжинд шаардлагатай зам тээвэр, шугам сүлжээний эх үүсвэр, цэвэрлэх байгууламж зэрэг бүс нутаг, хотын хөгжил, хүн амын нийтлэг хэрэгцээг тэтгэх барилга байгууламжуудыг барьж байгуулах асуудлыг үндэслэл тооцоотойгоор Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад оруулж шийдвэрлүүлэх, захиалагч байгууллагатай гэрээ байгуулж хяналт тавих.

3.13. Бүс нутгийн төсөл, хот суурингийн ерөнхий төлөвлөгөө, тухайлсан зураг төсөл боловсруулах, шилдэг санаа шалгаруулах уралдааныг зарлан дүгнэх ажлыг зохион байгуулах, оролцох, авторын эрх авах, зохиогчийн бүрэлдэхүүнд оролцох.

3.14. Нийслэлийн бүс нутгийн хөгжлийн үзэл баримтлал, хотын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд олон нийтэд сурталчлах, уулзалт семинар зохион байгуулах.

3.15. Архитектур, хот байгуулалтын төслүүдийн шаардлага хангаагүй зөрчсөн бол барилга, хот байгуулалтын хууль болон хот байгуулалтын норм, дүрэм журам, стандарт, барилга байгууламжийн байршил болон зураг төслийг хянаж, өөрчлүүлэх, хүчингүй болгож, барилгын ажлыг зогсоох. Мөн нийслэл Улаанбаатар хотын хот байгуулалт, барилгажилт, инженерийн хангамжийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах удирдлага, зохион байгуулалтын болон эрх зүйн зохицуулалт хийх санаачилга гаргах.

3.16. Архитектур, хот байгуулалтын талаар гарсан зөрчлийг байгууллагын эрх хэмжээ, өмчийн хэлбэрийг үл харгалзан хууль эрхийн дагуу засуулах, зогсоох, буулгах, гарсан хохирлыг нөхөн төлүүлэх, хуулийн байгууллагад шилжүүлэх ажлыг Мэргэжлийн хяналтын хэлтэс, эрх бүхий байгууллагын оролцоотойгоор цаг алдалгүй шийдвэрлүүлэх.

3.17. Харьяа байгууллагуудын удирдах албан тушаалтныг томилоход санал өгөх, тэдний ажлын талаар санал дүгнэлт гаргах.

3.18. Харьяа байгууллагуудын зохион байгуулалтын бүтцийг батлах, тэдгээрийг байгуулах, өөрчлөн зохион байгуулах, татан буулгах асуудлыг зохих журмын дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт оруулж шийдвэрлүүлэх.

3.19. Харьяа байгууллагуудын үйл ажиллагааны жил, хэтийн зорилт, төсвийн төслийг нэгтгэн боловсруулах, газрын батлагдсан төсвийг захиран зарцуулж тайлагнах.

3.20. Эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан хүмүүсийг төр, засгийн болон Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын шагналд уламжлах, газрын шагналаар шагнах.

3.21. Нийслэлийн Засаг даргаас шилжүүлсэн болон хууль тогтоомжоор олгогдсон бусад эрхийг эдлэх.